

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙН 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР
САРЫН ДҮНГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**



*Нэг.ТӨСӨВ, МӨНГӨ,ЗЭЭЛ,
ХАДГАЛАМЖ*

***2014 оны 1 дүгээр сард аймгийн төсвийн орлогын дүн 394.1 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.4 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна. 2014 оны 1 сард нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянцагаан, Баяновоо, Баацагаан, Бууцагаан сумаас бусад сумууд биелүүлээгүй байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ЦХТА орлого 46,4 сая төгрөг, ИОТТХ 4,1 сая төгрөг, патент 0,6 сая төгрөг, улсын тэмдэгт 0,4 сая төгрөг, хүү торгууль 8,6 сая төгрөгөөр тасарч, бусад нэр төрөлд биелэлээ. Нийт орлогод ААНБ орлогын албан татвар 2.0 хувь, нэмүү өртгийн албан татвар 9.9 хувь, ЦХТА орлого 65.1 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 0.3 хувь, бусад төлбөр хураамж 22.7 хувийг эзэлж байна.

***2014 оны 1 дүгээр сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 40245,3 сая төгрөгт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 103003,8 сая төгрөгт хүрчээ.

Чанаргүй зээл 481.1 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.4 хувийг эзэлж байна.



Хоёр. ҮНЭ ТАРИФ

“”””2014 оны 1 дүгээр сард өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тариф 2010 оны 12 сарынхаас 39,5 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 26,1 хувиар, өмнөх сарынхаас 2.5 хувиар өссөн байна. Хүнсний бараа ундаа усны бүлгийн дүн 2014 оны 1 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад 6.8 хувиар, хувцас, бөс бараа гутлын бүлгийн дүн 1,3 хувиар, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн дүн 1,7 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн дүн 3,1 хувиар, тээврийн үйлчилгээний бүлгийн дүн 2,4 хувиар өсч, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн дүн 3,7 хувь буурсан нь ерөнхий индекс 2.5 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.



Гурав. ХӨДӨӨ АЖ АХУЙ

***2014 оны 1 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээгээр 124 том мал зүй бусаар хорогдсон байна. Нийт хорогдлын 87.9 хувь нь Эрдэнэцогт, Баянбулаг, Баянхонгор сумдад гарчээ.



Дөрөв .АЖ ҮЙЛДВЭР

***2014 оны 1 дүгээр сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 476289,4 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 10933.2 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урд оны мөн үеэс нүүрс 3,3 мян.тн-оор өсч, дулаан 6,0 мян.г.калиар, талх 3.9 тн-оор, нарийн боов 1,7 тн-оор, архи 1,1 мянган литрээр буурчээ.



Тав. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

*** 2014 оны 1 дүгээр сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 1217.1 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 229.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 120.1 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 28,1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 0.9 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 44.6 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 10.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 4.2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1,9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын

сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 12.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 130.0 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 0.9 сая төгрөг олгожээ. Нийгмийн даатгалын төв газраас тэтгэврийн санхүүжилтэд 1300,0 сая төгрөг авсан байна.

*** Нийгмийн халамжийн сангаас 2014 оны 1 сард 7214 хүнд 417.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.2014 оны 1 сард Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1189 иргэнд 20.3 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж, 98 ахмадад 16.6 сая төгрөгийн нэг удаагийн хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй 73 иргэнд 8.3 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж олгожээ.



Зургаа. ЭРҮҮЛ МЭНД

***2014 оны 1 сарын байдлаар 166 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 41 хүүхдээр цөөн байна.Архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн онтой харьцуулахад сүрьеэ 1, гар хөл амны өвчин 2, гахай хавдар 1, салхин цэцэг 29 тохиолдолоор нэмэгдсэн байна.2014 оны 1 сарын байдлаар нас баралтын 34 тохиолдол бүртгэгдэж, эмнэлэгт нас баралт 32.3 хувийг эзэлж байна.



Долоо. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2014 оны 1 дүгээр сарын эцэст 1443 болж, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 62.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд 0.1 хувь нь магистр, доктор, 23.0 хувь нь дипломын, 6.7 хувь нь тусгай мэргэжлийн, 8.2 хувь нь техникийн мэргэжлийн, 34.8 хувь нь бүрэн дунд, 20.7 хувь нь бүрэн бус дунд, 5.3 хувь нь бага боловсролтой, 1.1 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг нь насны бүлгээр нь судлахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн 22.1 хувийг 15-24 насныхан, 36.9 хувийг 25-34 насныхан, 23.9 хувийг 35-44 насныхан, 16.6 хувийг 45-59 насныхан, 0,5 хувийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. 2014 оны 1 сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс 31 хүн ажилд зуучлагдан орсоны 22.5 хувь нь ХАА, ойн аж ахуй, ан агнуурын салбарт, 12.9 хувь нь боловсруулах үйлдвэрт, 3.2 хувь нь барилгын салбарт, 19,3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажилд зуучландан оржээ.



Найм.ГЭМТ ХЭРЭГ

***2014 оны 1 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 32 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 27.3 хувиар буурч, бүх гэмт хэргийн 28.1 хувийг хөнгөн, 59.3 хувийг хүндэвтэр, 9.4 хувийг хүнд, 3.1 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт

хэрэг зөрчлийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 17.9 сая төгрөгийн хохирол учирч, 0,3 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлжээ. Гэмт хэрэгт 37 хүн холбогдогдсоны 8.1 хувь нь 14-17 насны хүүхэд, 91.8 хувь нь 18-аас дээш насныхан холбогдсон байна. Нийт гэмт хэргийн 62.5 хувь нь Баянхонгор суманд, 37.5 хувь нь бусад сумдад үйлдэгдсэн байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС